

# “ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр

дугаар *ДМ-6.8/301*

Дархан-Уул аймаг

Ногдол ашгийн хэмжээг  
өөрчлөх тухай

Дархан нэхий ХК-ийн 2023 оны 06 сарын 21-ны өдрийн 115 тоотор “Голомт банктай хийсэн зээлийн гэрээний Дархан нэхий ХК-ийн ноогдол ашгийн хэмжээг 250 саяаас хэтрүүлэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд энэ талаар Голомт банкны зүгээс гэрээний заалтыг зөрчихгүй байхыг сануулсан учир “Ногдол ашгийн хэмжээг өөрчлөх” тухай хүсэлтийг ТУЗ-д ирүүлсэнтэй холбогдуулан Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь заалтуудыг удирдлага болгон **ТОГТООХ нь:**

1. Дархан нэхий Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн тогтоолоор 2022 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахаар, нэгж хувьцаанд 0,27 төгрөг буюу нийт 300,000,000 (гурван зуун сая) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн боловч, Голомт банкнаас жилийн ногдол ашгийн хэмжээг 250 сая төгрөгөөс дээш олгож болохгүй гэсэн Зээлийн гэрээнд заасан нөхцлийг чанга барьж ажиллахыг удаа дараа анхааруулж байгаатай холбогдуулан Дархан нэхий ХК-ийн 2022 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг нийт 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгөөр хуваарилахаар өөрчлөн тогтоосугай.
2. Ногдол ашгийн хэмжээнд өөрчлөлт оруулсан тухай шийдвэрийг Компанийн тухай хуулийн дагуу мэдээлэл хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х. Нарантуяад үүрэг болгосугай.
3. Дархан нэхий ХК-ийн гүйцэтгэх удирдлага, санхүүд энэ тогтоолд заасан хэмжээгээр ногдол ашгийн өглөгийн хэмжээг засварлан бүртгэж, хагас жилийн балансад тусгахыг даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э. БАТСАЙХАН